



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	12
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв:	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2. Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХҮДЭР СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ В.ЦЭРЭНСҮРЭН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № СЭА-2025/181/НА-СЯ-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жил бүр “Шилдэг хөрөнгө оруулагч анги” шалгаруулдаг бөгөөд тайлант онд уг ажлын хүрээнд эцэг эхчүүдээс 4,390.0 мянган төгрөгийн үнэ бүхий хивсэнцэр, дрожийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж,

баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 84.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	207,003,775.46	256,255,945.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,407,689.46	170,602,472.90
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	141,407,689.46	170,602,472.90
3121	Төгрөг	141,407,689.46	170,602,472.90
31211	Төрийн сангийн харилцах	141,407,689.46	170,602,472.90
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	65,596,086.00	85,653,472.80
354	Хангамжийн материал	65,596,086.00	85,653,472.80
3541	Бичиг хэргийн материал	456,000.00	533,600.00
3542	Аж ахуйн материал	45,802,156.00	53,542,586.80
3546	Хүнсний материал	5,633,680.00	2,885,536.00
3547	Бусад хангамжийн материал	13,704,250.00	28,691,750.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,181,278,907.39	1,143,985,183.68
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,181,278,907.39	1,143,985,183.68
392	Биет хөрөнгө	1,171,204,907.39	1,133,911,183.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,300,331,468.19	1,300,331,468.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-176,123,332.89	-215,731,021.65
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,987,804.00	52,012,580.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,053,056.12	-27,062,181.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,886,738.50	65,462,289.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,243,331.19	-44,874,786.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,957,813.50	7,957,813.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,978,906.60	-4,774,687.92
39217	Ном	439,710.00	589,710.00
393	Биет бус хөрөнгө	10,074,000.00	10,074,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,074,000.00	10,074,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,388,282,682.85	1,400,241,129.38
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	68,750.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,750.00	
413	Өглөг	68,750.00	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	68,750.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,388,213,932.85	1,400,241,129.38
51	Засгийн газрын хувь оролцоо	1,388,213,932.85	1,400,241,129.38

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	85,202,272.00	85,202,272.00
51101	Өмч: - төрийн	85,202,272.00	85,202,272.00
512	Хуримтлагдсан үр дүн	512,415,635.97	521,392,832.50
5121	Өмнөх үеийн үр дүн	512,415,635.97	512,415,635.97
5122	Тайлант үеийн үр дүн		8,977,196.53
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,596,024.88	793,646,024.88
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,388,282,682.85	1,400,241,129.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	763,454,870.00	982,693,194.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,680,870.00	17,013,030.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,680,870.00	17,013,030.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,720,000.00	12,623,030.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,960,870.00	4,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,774,000.00	965,680,164.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	696,937,900.00	907,618,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	696,937,900.00	907,618,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,836,100.00	58,062,164.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,836,100.00	58,062,164.27
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	675,120,457.21	973,715,997.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	675,120,457.21	973,715,997.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,120,457.21	973,715,997.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,314,200.02	676,012,970.08
210101	Үндсэн цалин	323,607,392.03	438,428,328.54
210102	Нэмэгдэл	96,686,217.99	219,590,684.86
210104	Урамшуулал	7,020,590.00	17,993,956.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,917,511.62	85,841,799.48
210201	Тэтгэврийн даатгал	37,535,619.76	59,280,354.17
210202	Тэтгэмжийн даатгал	4,407,772.89	7,056,482.21

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,464,697.55	3,416,140.97
210204	Ажилгүйдлийн даатгал	824,674.79	3,217,823.24
210205	Эрүүл мэндийн даатгал	8,684,746.63	12,870,998.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,366,100.00	54,592,164.27
210301	Гэрэл, цахилгаан	7,697,406.71	7,331,124.27
210302	Түлш, халаалт	40,517,893.29	41,081,040.00
210303	Цэвэр, бохир ус	5,150,800.00	6,180,000.00
2105	Нормативт зардал	64,183,507.00	78,316,739.00
210502	Хоол, хүнс	64,183,507.00	78,316,739.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,470,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	6,470,000.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,273,358.00	1,359,402.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,273,358.00	1,359,402.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,595,780.57	74,122,922.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,729,960.00	14,242,962.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,458,000.00	5,953,207.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,407,820.57	53,926,753.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,334,412.79	8,977,196.53
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,334,412.79	8,977,196.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	751,774,000.00	965,680,164.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,774,000.00	965,680,164.27

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	696,937,900.00	907,618,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	696,937,900.00	907,618,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,836,100.00	58,062,164.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,836,100.00	58,062,164.27
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	625,824,354.64	935,525,380.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,824,354.64	935,525,380.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625,824,354.64	935,525,380.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,314,200.02	676,012,970.08
210101	Үндсэн цалин	323,607,392.03	438,428,328.54
210102	Нэмэгдэл	96,686,217.99	219,590,684.86
210104	Урамшуулал	7,020,590.00	17,993,956.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,848,761.62	85,910,549.48
210201	Тэтгэврийн даатгал	37,488,869.76	59,327,104.17
210202	Тэтгэмжийн даатгал	4,402,272.89	7,061,982.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,453,697.55	3,427,140.97
210204	Ажилгүйдлийн даатгал	823,574.79	3,218,923.24
210205	Эрүүл мэндийн даатгал	8,680,346.63	12,875,398.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,366,100.00	54,592,164.27
210301	Гэрэл, цахилгаан	7,697,406.71	7,331,124.27
210302	Түлш, халаалт	40,517,893.29	41,081,040.00
210303	Цэвэр, бохир ус	5,150,800.00	6,180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	68,098,293.00	75,568,595.00
210502	Хоол, хүнс	68,098,293.00	75,568,595.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,470,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	1,470,000.00	3,470,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,409,100.00	1,359,402.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,409,100.00	1,359,402.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,317,900.00	38,611,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,090,600.00	29,566,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,227,300.00	9,045,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	125,949,645.36	30,154,783.44
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,166,000.00	960,000.00
	Дотоод эх үүсвэрээр	5,166,000.00	960,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,166,000.00	960,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,166,000.00	-960,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	120,783,645.36	29,194,783.44
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		141,407,689.46
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		170,602,472.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,202,272.00	790,596,024.88	512,415,635.97	1,388,213,932.85
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		3,050,000.00		3,050,000.00
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			8,977,196.53	8,977,196.53
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,202,272.00	793,646,024.88	521,392,832.50	1,400,241,129.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,107,087,853.73	936,485,380.83	170,602,472.90	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,107,087,853.73	935,525,380.83	171,562,472.90	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,107,087,853.73	935,525,380.83	171,562,472.90	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,948,600.00	676,012,970.08	28,935,629.92	95.9
210101	Үндсэн цалин	584,623,789.46	438,428,328.54	146,195,460.92	98.9
210102	Нэмэгдэл	255,561,400.00	219,590,684.86	35,970,715.14	85.9
210104	Урамшуулал	6,171,100.00	17,993,956.68	-11,822,856.68	291.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,153,800.00	85,910,549.48	9,243,250.52	90.3
210201	Тэтгэврийн даатгал	64,706,300.00	59,327,104.17	5,379,195.83	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,610,500.00	7,061,982.21	548,517.79	92.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,806,100.00	3,427,140.97	378,959.03	90.0

210204	Ажилгүйдлийн даатгал	3,806,100.00	3,218,923.24	587,176.76	84.6
210205	Эрүүл мэндийн даатгал	15,224,800.00	12,875,398.89	2,349,401.11	84.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,592,164.27	54,592,164.27	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,331,124.27	7,331,124.27	0.00	100.0
210302	Түлш, халаалт	41,081,040.00	41,081,040.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,180,000.00	6,180,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал			0.00	
2105	Нормативт зардал	72,190,400.00	75,568,595.00	-3,378,195.00	104.7
210502	Хоол, хүнс	72,190,400.00	75,568,595.00	-3,378,195.00	104.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,015,300.00	1,359,402.00	1,655,898.00	45.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,015,300.00	1,359,402.00	1,655,898.00	45.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,309,900.00	38,611,700.00	-6,301,800.00	119.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,264,200.00	29,566,000.00	-6,301,800.00	127.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,045,700.00	9,045,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг			0.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		960,000.00	-960,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		960,000.00	-960,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,107,087,853.73	965,680,164.27	141,407,689.46	87.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,049,025,689.46	907,618,000.00	141,407,689.46	86.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	907,618,000.00	907,618,000.00	0.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	141,407,689.46		141,407,689.46	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			0.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,062,164.27	58,062,164.27	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	58,062,164.27	58,062,164.27	0.00	100.0
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			0.00	
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			0.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС			0.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		141,407,689.46	-	141,407,689.46
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		170,602,472.90	-	170,602,472.90

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Суралцагчийн танин мэдэхүйн, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл хөдлөлийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, багшлахуй ба суралцахуйн дадал, хөгжил төлөвшил чадварын чанар, үр дүнг сайжруулах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн хараад ойлгох чадварыг хичээл сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулж, өдөр тутмын үйл ажиллагааг чанартай явуулах;
- Багш бүр ажлын байран дээрээ хөгжиж, мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллан, байгууллагын эерэг уур амьсгал, соёлыг төлөвшүүлэх;
- Байгууллагын менежмент, үнэлгээнүүдийн ур дүнг сайжруулж, ТАТ /тогтмол ажлын төлөвлөгөө/, САТ /сарын ажлын төлөвлөгөө/-г хэрэгжүүлж, цахим платформд суурилсан сургалтыг явуулах орчин, дэд бүтцийг хөгжүүлэх;
- Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд бүрийн тэгш, хүртээмжтэй хамруулан, эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, боломжийг бүрдүүлэх;
- Санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотой төлөвлөж, хэрэгжилтийг үр дүнтэй, ил тод, нээлттэй байлгах;

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус цэцэрлэг нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,958.4 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	141,407.7	170,602.5	29,194.8
Авлага			
Бараа материал	65,596.1	85,653.5	20,057.4
Үндсэн хөрөнгө	1,181,278.9	1,143,985.2	(37,293.7)
Нийт хөрөнгө	1,388,282.7	1,400,241.1	11,958.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,388,213.9	1,400,241.1	12,027.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,388,282.7	1,400,241.1	11,958.4

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 170,602.5 мянган төгрөг болж 29,194.8 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 -д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлсөн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 85,653.5 мянган төгрөг болж 20,057.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 110,503.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, иргэдээс 4,390.0 мянган төгрөгийн хивс дроз үнэ төлбөргүй хүлэн авсан, үйл ажиллагаанд 94,836.0 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,436,427.8 мянган төгрөг болж 5,249.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 960.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн Боловсролын газраас 1,797.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, зөөврийн компьютер, ААН иргэдээс 10,826.0 мянган төгрөгийн хандив зэрэг нийт 12,623.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 292,442.6 мянган төгрөг бөгөөд 1,143,985.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 726,679.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 64,109.3 мянган төгрөг, нийт 790,789.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 132,762.5 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 4,919.0 мянган төгрөгөөр нийт 137,681.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлыг 28,514.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,569.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 55,607.9 мянган төгрөгөөр нийт 86,691.3 мянган төгрөгөөр бууруулж төсвийг 841,779.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 907,618.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 58,062.1 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 141,407.5 мянган төгрөгөөр нийт 1,107,087.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 244,388.2 мянган төгрөгөөр,
- Хүүхдийн хоолны зардлыг 5,851.5 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,623.6 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 19,492.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,107,087.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж үндсэн үйл ажиллагаанд 936,485.4 мянган төгрөгийг зарцуулж, 170,602.5 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 936,485.4 мянган төгрөг буюу 84.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	71802-Сургуулийн өмнөх боловсрол	1	80233- Хүүхэд хамгаалал	1,325.0	1,325.0	-	100.0
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	72,190.4	75,568.6	-3,378.2	104.6
		3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,665.6	3,665.6	-	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	2,877.2	2,110.0	767.2	73.3
		5	81834- Боловсролын стандарт сургалт	952,677.0	779,621.7	173,055.3	83.4
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	4,152.3	4,152.3	-	100.0
		7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	58,062.2	58,062.2	-	100.0
		8	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,138.2	1,980.0	158.2	92.6
		9	83602-Нийтлэг үйлчилгээ	10,000.0	10,000.0	-	100.0
Нийт				1,107,087.9	936,485.4	170,602.5	84.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	83,875.7	83,875.7	НТШ
	Нийт дүн	83,875.7	83,875.7	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Шинэ үерт” ХХК-тай гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих, бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг биет бус хөрөнгийн ангилалд бүртгэх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг

дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 675,120.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,751.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 удаа;

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 удаа

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 914 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 32,053.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,083.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 30,970.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар эрхлэгч В.Цэрэнсүрэнгийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Засгийн газрын 2019 оны

5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.11 дэх "Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 30,520.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

2.2. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1 "Аж ахуй нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалт болон УСНББОУС-31-д "Биет бус хөрөнгө " Биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ эрх, давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг биет бус хөрөнгө гэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй байгаа биет бус хөрөнгийг эдийн засгийн ангиллаар нь зөв бүртгэх;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрхлэгчид мөнгөн шагнал олгосон	1	1,083.8	1	1,083.8								
Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд өгсөн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	30,520.0					1	30,520.0				
НБ-ийн програм хангамжийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	450.0					1	450.0				
Дүн	3	32,053.8	1	1,083.8			2	30,970.0				-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					-	1
Дүн	1	-					-	1



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 24/11850385

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар эрхлэгч В.Цэрэнсүрэнгийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т “Төлбөрийн акт

432505072

тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.2: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урамшуулалд олгосон 1,083.8 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч В.Цэрэнсүрэн, нягтлан бодогч Д.Баяржаргал нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

Албан шаардлага, төлбөрийн актын бүртгэл, хяналтын хуудас

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл хяналт

1. Үндсэн мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/181-НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийх үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага, төлбөрийн актын дугаар	СЭА-2025/181-НА-СТА-ТШЗ	1.6 Тогтоосон огноо	2/24/2025	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,083,800.0

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих		Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25 ны өдрийн Б/02 дугаар захирамжаар эрхлэгч В.Цэрэнсүрэнгийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай		
	Алдаа, зөрчлийн ангилал		Төлбөрийн акт		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)		Журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.6.2		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол		
Заалт		3 дугаар хавсралт			
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам",			
	Заалт	Хуулийн 21.2, журмын 4.2.3, 4.2.3.3,			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1,083,800.0	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
				6/15/2025

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Цалингийн баримт,		2024 он	
2	Сумын ЗД-ын захирамж		2024 он	

3 Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

Аудитын багийн		Хариуцагч			
Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих утас
Б.Наранчимэг	Аудитор	Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг	Эрхлэгч	В.Цэрэнсүрэн	95659211
			Нягтлан бодогч	Д.Баяржаргал	94041107

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	2/24	=	
2	Тэргүүлэх аудитор	11/05	=	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор		11/05	

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2/24/2025	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг	
		Ажилтны	Овог нэр	Д.Баяржаргал
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Байгууллагын нэр	Пийк Ом аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөж		